

## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.11.05-11.09

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцааны ханш өсчээ. Харин "Netflix" компани болон видео тоглоом хөгжүүлэгч компаниудын хувьцааны ханш буурснаар мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш унасан байна. Мөн газрын тосны үнийг даган эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байв.

АНУ-д хоёр жил тутамд явагддаг завсрын сонгуулийн урьдчилсан дүнгээр Бүгд Найрамдах нам Сенатын танхимд давуу байр сууриа хадгалж үлдлээ. Харин Ардчилсан нам Төлөөлөгчдийн танхимд олонх болж чадсан байна. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн индексүүд өсчээ.

Бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчид үнээ нэмж, АНУ-ын хэрэглээний үнийн индекс огцом өссөн байна.

**Европ:** Хувьцаат компаниудын 3-р улирлын санхүүгийн тайлангийн хангалтгүй үзүүлэлт, Итали улс болон Европын холбооны хоорондын харилцааны хагарал, худалдааны маргааны тодорхой бус байдал зэргээс хамааран Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд харьцангуй тогтвортой байлаа.

Италийн Засгийн газар ирэх оны төсвийн зардлаа танаж, дотоодын нийт бүтээгдэхүүний 131 хувьтай тэнцээд байгаа өрийн хэмжээгээ бууруулахгүй бол Европын Холбоо Италийн Засгийн газарт эдийн засгийн хориг тавих хүртэл эрсдэлтэй тулгарахыг шинжээчид анхааруулж байна.

Европын бүсийн эдийн засаг удааширч, АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан тус бүсийн экспортын түвшинд нөлөөлж байгаа ажээ. Европын комиссийн үзэж байгаагаар худалдааны маргаан, газрын тосны үнийн өсөлт болон бусад улс төрийн тодорхойгүй байдлаас шалтгаалан Европын бүсийн эдийн засгийн өсөлт 2020 он гэхэд удааширна хэмээн үзжээ. Европын бүсийн борлуулалтын менежрүүдийн индекс 10-р сард 53.1 нэгж болж, 2016 оны 9-р сараас хойшхи хамгийн доод түвшинд хүрчээ.

**Япон:** Японы хөрөнгийн зах зээлийн индекс тогтвортой байлаа. Японы хувьцаат компаниудын хагас жилийн санхүүгийн тайлан 9-р сарын 30-ны өдөр гардаг бол жилийн эцсийн тайлан 3-р сард гардаг билээ. Японы TOPIX индексийн сагсанд багтдаг компаниудын тал нь санхүүгийн тайлангаа ирүүлсэн ба үүнээс 708 компанийн цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8%-аар өсчээ.

Японы аж үйлдвэрлэлийн гарц, ажилгүйдлийн түвшин болон жижиглэнгийн худалдааны үзүүлэлтүүд тус улсын эдийн засгийн өсөлт удааширч байгааг илтгэж байна хэмээн шинжээчид үзжээ.

**БНХАУ:** АНУ-ын гаалийн татварын арга хэмжээнээс үл хамаарч БНХАУ-ын экспортын хэмжээ 10-р сард огцом өссөн үзүүлэлттэй байна. Хятад улсын экспортын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.6%-аар нэмэгджээ. Импортын хэмжээ мөн адил нэмэгдсэн хэдий ч АНУ-аас орж ирэх импорт багассан байна.

Экспортын хэмжээ ийнхүү нэмэгдэхэд хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудын талаас эрэлт өндөр байсан, мөн аж ахуйн нэгжүүд гаалийн татварын арга хэмжээ үйлчилж эхлэхээс өмнө бараагаа их хэмжээгээр татсантай холбоотой юм. Үүнээс гадна, юанийн ханш суларч, Хятадын бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сайжирсан билээ. БНХАУ-ын юань ам. долларын эсрэг сүүлийн 6 сарын хугацаанд 9%-аар суларсан үзүүлэлттэй байна.

Эх сурвалж: Reuters, Troweprice

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,560.70	-0.25% ▼
Dow Jones	АНУ	25,989.30	2.84% ▲
S&P 500	АНУ	2,781.01	2.13% ▲
Nasdaq	АНУ	7,406.90	0.68% ▲
S&P/TSX	Канад	15,274.44	1.03% ▲
FTSE 100	Их Британи	7,105.34	0.16% ▲
S&P/ASX 200	Австрали	5,921.80	1.24% ▲
Nikkei 225	Япон	22,250.25	0.03% ▲
Hang Seng	Хонг Конг	25,601.92	-3.34% ▼

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	108.72
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	96.59
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	95.74
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.58
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.53
DBM' 2023	USD	7.250%	98.93
TDBM' 2020	USD	9.375%	105.40

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.314	-0.00 ▼
Libor 3M	2.618	0.03 ▲
Libor 6M	2.858	0.03 ▲
Libor 1YR	3.144	0.04 ▲
US 6M Bond	2.514	0.03 ▲
US 2YR Bond	2.924	0.03 ▲
US 3YR Bond	2.993	0.03 ▲
US 5YR Bond	3.035	0.01 ▲
US 10YR Bond	3.182	-0.02 ▼

### Валютын ханш /төг/

Валют	2018.11.07	Өөрчлөлт
USD	2,566.89	0.04% ▲
CNY	370.42	-0.43% ▼
EUR	2,940.50	0.22% ▲
RUB	38.86	-0.69% ▼
KRW	2.29	0.00% ▲
JPY	22.70	-0.04% ▼
CAD	1,955.73	-0.50% ▼

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,210.93	-1.71% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	14.20	-3.47% ▼
Зэс	USD/lb.	269.75	-3.28% ▼
Нүүрс	USD/MT	104.60	1.70% ▲
WTI газрын тос	USD/bbl.	60.76	-3.05% ▼
Brent газрын тос	USD/bbl.	71.02	-1.92% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	3.77	9.28% ▲

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. IX	5.70%
Бодлогын хүү	2018. IX	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. IX	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. IX	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. IX	5.10%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. IX	17.50%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. IX	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 32 компанийн 394.5 сая төгрөгийн 2,045,797 ширхэг хувьцаа арилжигдав.

“Хай Би Ойл” /HBO/ компанийн хувьцаа 26.19%-аар буюу хамгийн ихээр өсч 53 төгрөгт хүрч хаагдсан бол “Монинжбар” /MIB/ компанийн хувьцаа 27.72%-аар буурч 130.1 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


11-р сарын 07-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,410.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,560.70 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.25%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	394.5
Зах зээлийн үнэлгээ	2,410,427.5

### Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,560.70	-0.25% ▼
MSE I индекс	9,833.64	-0.34% ▼
MSE II индекс	8,717.08	0.60% ▲

### Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	1,631,743	122,015,426
Мандал даатгал	18289	90,614,680
АПУ	65,877	38,229,813
Ард даатгал	47,283	35,986,335
Хөвсгөл алтан дуулга	37,230	24,201,090

### Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хай Би Ойл	53.00	26.19% ▲
Ремикон	30.00	25.00% ▲
Хархорин	1,600.00	14.29% ▲
Могойн гол	5,605.00	12.10% ▲
Улсын их дэлгүүр	455.00	6.89% ▲

### Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монинжбар	130.10	-27.72% ▼
Махимпекс	30.00	-7.41% ▼
Эрдэнэ ресурс девелопмент корп.	1,600.00	-7.07% ▼
Сүү	5,605.00	-2.95% ▼
Таван толгой	455.00	-1.10% ▼

### Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Голомт капитал	212,302,610
Новел инвестмент	207,362,116
Бумбат-Алтай	76,868,307
Ард секьюритиз	42,584,419
Би Ди Сек	39,525,991

### Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	582.89	620,301
Таван толгой	7,655.00	403,152
Говь	34,200.00	266,798
МИК	11,000.00	227,803
Сүү	230.00	79,120

## ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюты фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Материал импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Материал импекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2018 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн 63.54 хувийн ирцтэйгээр хуралдсан бөгөөд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид 100 хувь зөвшөөрсний дагуу “Материал кредит” ХХК-ийг үүсгэн байгуулж, түүнтэй холбогдох өөрчлөлтүүдийг компанийн дүрэмд тусгахаар шийдвэрлэсэн байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### Үнэт цаасны компаниудын төлөөлөлтэй уулзаж, санал солилцлоо

Санхүүгийн зохицуулах хороо 11-р сарын 05-ны өдөр үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөлтэй 54 компанийн төлөөлөлтэй уулзаж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх Хорооны 2016 оны 94 дүгээр тогтоолын хэрэгжилтийн шаардлагыг хангах болон “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаатай холбоотой асуудлуудаар санал солилцлоо.

ҮЦГ-ын дарга Б.Лхагвасүрэн, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 хувьцаа талаар олон нийтэд нэгдмэл бус, харилцан адилгүй байр суурийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд өгч байгаа нь иргэдэд эргэлзээ төрүүлж байгааг анхааруулав. Тус компанийн хувьцаатай холбоотойгоор иргэдийн үнэт цаасны дансаа нээлгэх идэвхи сэргэж буйг ашиглан нийгмийн сүлжээгээр болон албан бус маягт бөглүүлэх замаар зөвлөгөө өгөхгүйгээр данс нээх үйлдэл гарч, энэ талаар Хороонд цөөнгүй санал, гомдол ирж байгаа талаар мэдээллээ. Мөн Хороонд бүртгэлтэй 54 компанийн 37 нь буюу 68 хувь нь гуравдугаар улирлын тайлангаа ирүүлээгүй, эрсдэлийн сангийн шаардлагыг компаниудын 18 орчим хувь хангаагүй, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулахдаа заавал салбарын тусгай зөвшөөрөл авсан байх зэрэг олон асуудлыг хөндөж, үнэт цаасны цахим үйлчилгээний техникийн боломжийг бүрдүүлэх, хувьцааны данс нээх үйл явцын тодорхой хэсгийг цахимаар явуулж болох эсэх гэх мэт асуудлаар санал солилцлоо.

ХШЗГ-ын орлогч дарга Б.Долгорсүрэн ҮЦК-уудаас гаргадаг нийтлэг зөрчил, дутагдлын талаар ярьж, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх 94 дүгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгааг онцлов. Уг тогтоолын хэрэгжилтийг бүртгэлтэй 54 компанийн 33 нь хангаж, үлдсэн 21 компани хангаагүй байна. Түүнчлэн үнэт цаасны компаниудад мөнгө угаах, терроризмтэй тэмцэхтэй холбоотой хоёр удаагийн шалгалт явуулахад боловсон хүчин дутмаг, иргэдэд зөвлөгөө өгч ажиллах ур чадвар тааруу байсны зэрэгцээ суурин хаяггүй компаниуд ч олон байсны тэрээр дурдлаа. Тусгай зөвшөөрөл авснаасаа хойш үнэт цаасны арилжаанд оролцоогүй, тун цөөхөн оролцсон компаниуд ч цөөнгүй байгааг болон андеррайтерийн эрх олгосон 23 компанийн ердөө тав нь шаардлага хангаж ажиллаж байгааг тэрээр сануулав. Иймд цаашид Хороо харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг олон улирал дараалан хангаагүй компаниудад хатуу хариуцлага тооцож ажиллахаа мэдэгдэж, компани тус бүрийн үйл ажиллагааны болон санхүүгийн үзүүлэлтэд харгалзах асуудлыг тусгасан албан мэдэгдлийг гардуулан өгсөн юм. Мөн орон нутагт салбар нээх зөвшөөрөлгүй атлаа үнэт цаасны данс нээсэн цөөнгүй тохиолдол гарч байгааг Б.Долгорсүрэн сануулж, энэ зөрчил дутагдлыг засахгүй бол хуулийн дагуу шат дараатай арга хэмжээ авахыг анхааруулав.

**Эх сурвалж:** Санхүүгийн зохицуулах хороо

### СЗХ: Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ III улиралд өмнөх оны мөн үеэс 12.8 хувиар өссөн

Үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ энэ оны III улиралд өмнөх оны мөн үеэс 12.8 хувиар өсч, 2.35 их наяд төгрөгт хүрсэн талаар Санхүүгийн зохицуулах хороо мэдээллээ.

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 200 гаруй компаниас 30 нь нийт үнэт цаасны зах зээлийн үнэлгээний 91.9 хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл эдгээр компаниудын хувьцааны ханш, ялангуяа I ангилалд бүртгэлтэй, “Топ 20”-ийн сагсанд багтдаг компаниудын хувьцааны ханш өссөн нь голлон нөлөөлсөн байна. “Топ 20” индекс III улиралд өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар өсч, 20 мянган нэгжийг давжээ.

“Говь” ХК-ийн хувьцааны ханш энэ хугацаанд 90 орчим хувиар, “Сүү” ХК-ийн хувьцааны ханш 30 гаруй хувиар тус тус өссөн байна. Мөн зах зээлийн үнэлгээгээр “Топ 10”-т багтдаг “Евроазиа капитал холдинг” компанийн хувьцааны ханш найм дахин өссөн байна.

Үүнээс гадна Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 2017 оны IV улиралд зогссон юм. Өмнөх онд Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа идэвхтэй явагдаж нийт үнэт цаасны арилжааны 80 гаруй хувийг дангаараа бүрдүүлж байжээ. Харин энэ онд Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа зогссонтой холбоотойгоор арилжааны үнийн дүн буурсан байна.

Харин хувьцааны арилжаа энэ оны III улиралд өмнөх оныхоос дөрөв дахин өсөөд байгаа юм. Үүнд хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа идэвхжиж, III улиралд хэд хэдэн компани IPO гаргаж, нэмж хувьцаа гаргасан нь голлон нөлөөлсөн байна. Ерөнхий үзүүлэлтийг харвал III улиралд Монголын Хөрөнгийн биржид нийт 28.3 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 86 хувиар буурсан үзүүлэлт болжээ. Мөн Монголын Үнэт цаасны биржид оны эхний гурван улиралд 279.6 сая төгрөгийн хувьцаа арилжигдсан байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### “Эрдэнэ ресурс девелопмент корпорейшн” ХК үнэт цаасны компаниудад танилцуулга хийлээ

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн” ХК нь компанийн үйл ажиллагааны тайлан, цаашдын төлөвлөгөөний талаар 2018 оны 11-р сарын 6-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудад танилцууллаа. Тус компани нь 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Баян Хөндий алтны ордын NI 43-101 эрдсийн нөөцийн тайланг Канад улсын SEDAR буюу тайлан бүртгэлийн цахим системд оруулж, нийтэлсэн бөгөөд энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн билээ.

Танилцуулгын үеэр Гүйцэтгэх захирал Петер Акерли “Бид Хөндий алтны төслийг ашиглалтын түвшинд хөгжүүлэхээс гадна шинээр илрүүлсэн алтны дүүрэгт шинэ ордууд илрүүлэх, одоогийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хайгуулын хөтөлбөрийг үргэлжлүүлнэ. Алтан Сум, Хойд Хөндийн хайгуулын хөтөлбөрөөс гадна манай техникийн баг Монгол улсын баруун өмнөд бүсийн боломжит хайгуулын талбайнуудад хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар авах боломжуудыг судалж байна” гэж мэдэгдлээ. Түүнчлэн, тус компани дотоодын хувьцаа эзэмшигчдэд зориулан өөрийн цахим хуудасны Монгол хэл дээрх хувилбарыг ашиглалтанд оруулсан тул хөрөнгө оруулагчид [www.erdene.com](http://www.erdene.com) цахим хуудсанд зочлон компанийн талаарх мэдээллийг цаг алдалгүйгээр баталгаат эх үүсвэрээс авах боломжтой болсон байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### TRQ: “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн өмнөөс хийсэн санхүүжилт IX/30-ны байдлаар нэг тэрбум ам.доллар

2011 онд байгуулсан “Нэмэлт өөрчлөлт оруулж дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ”-нд заасны дагуу “Turquoise Hill Resources” компани хувьцааны хөрөнгө оруулалт болон хувь нийлүүлэгчийн өр хэлбэрээр “Оюу Толгой” төсөлд шаардлагатай бэлэн мөнгөний санхүүжилт хийсэн байдаг. Энэ дагуу ногдол ашиг тарааж эхлэхээс өмнө хувь нийлүүлэгч талын өр хэлбэрээр хийсэн санхүүжилтийг хүүтэй нь бүрэн эргүүлэн төлөх шаардлагатай юм байна.

9-р сарын 30-ны байдлаар “Оюу Толгой”-ийн хувь нийлүүлэгчийн зээл дэх баланс 4.7 тэрбум ам.доллар болжээ. Үүнд 0.6 тэрбум ам.долларын хүүгийн төлбөр багтаж байгаа юм байна. Харин хувьцааны санхүүжилт хэлбэрээр “Turquoise Hill Resources” компани “Оюу Толгой” ХХК-ийн 34 хувийг эзэмшиж байгаа “Эрдэнэс Оюу Толгой” компанийн өмнөөс хийсэн санхүүжилтийн хэмжээ 9-р сарын 30-ны байдлаар нэг тэрбум ам.долларт хүрсэн талаар “Turquoise Hill Resources”-ийн санхүүгийн тайланд дурдсан байна.

“Rio Tinto” группийн Зэс, очир эрдэнийн группийн Гүйцэтгэх захирал Арнауд Суарат хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Төслийн зээлийн хүүг бууруулах ажлын хэсэг ажиллаж байгаа. Монгол Улсын Засгийн газар “Turquoise Hill Resources” компаниас “Оюу Толгой” төслийг хөгжүүлэхээр авсан зээлийнхээ хүүг бууруулах хүсэлт удаа дараа тавьсан. Хүүг бууруулахын тулд гэлээд төслийн эрсдэлийг багасгах ёстой. Иймээс Засгийн газартай төслийн эрсдэлийг бууруулах гэж юуг хэлэх вэ, хэрхэн бууруулах вэ гэдэг дээр ажиллаж байна” гэж дурджээ.

Харин ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар “Оюу Толгой” ХХК-ийн хөрөнгө оруулагчидтай “Зээлийн хүүг бууруулах талд зарчмын тохиролцоонд хүрсэн” гэж өмнө нь мэдээлж байв. Мөн “Монголын талын өгөөж хүртэх хугацааг наашлуулах талаар яриа хэлэлцээ хийж байгаа” гэсэн юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



### Тавантолгой-Гашуунсухайтын 250 км замыг 2.5 жилд тавина

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай автозамыг “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” нөхцөлөөр “Тал нутгийн хөгжлийн зам” компанитай концессын гэрээ байгуулахыг Засгийн газрын 10-р сарын 31-ний өдрийн хуралдаанаар шийдвэрлэн зөвшөөрсөн.

Дээрх компани гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 2.5 жилд багтаан барих бөгөөд 12 жил ашиглаж төрд шилжүүлэх юм. “Тал нутгийн хөгжлийн зам” компанид төрөөс санхүүгийн ямар нэгэн дэмжлэг, баталгаа гаргахгүй. Зам баригдсанаар нүүрсний экспортын 50-60 хувийг тээвэрлэдэг замын урсгал сайжирч, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө эрс багасна гэж үзэж байна.

Мөн Тавантолгой-Ханбогд-Ханги чиглэлийн хатуу хучилттай автозамын төслийн явцыг хэлэлцэв. УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолд заасны дагуу Тавантолгой-Оюутолгой-Ханги чиглэл болгон өөрчлөн “Нако” компанитай концессын гэрээний хэлэлцээ хийж, санал дүгнэлтээ танилцуулахыг Үндэсний хөгжлийн газрын даргад Б.Баярсайхан даалгав гэж Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс мэдээллээ.

**Эх сурвалж:** MongolianMiningJournal.com

### АНУ Ираны газрын тосны экспортыг бууруулах хориггоо сэргээв

Ираны эрчим хүчний салбарт тавьж байгаа АНУ-ын Засгийн газрын хориг 11-р сарын 05-ны өдрөөс албан ёсоор хэрэгжиж эхэлжээ. Хориг арга хэмжээний хүрээнд Ираны газрын тосны экспортыг огцом бууруулах юм.

Иранаас газрын тос импортоор авдаг бусад улсад ч дээрх шийдвэрийн хэрэгжилтийг дагах аж. АНУ-ын Засгийн газар 8 улсад түр хугацаанд Иранаас авах импортоо үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон. Ираны эрх баригчид 2015 онд байгуулсан цөмийн хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр АНУ хэлэлцээрээс гарч байгаа гэдгийг Дональд Трамп 5-р сард мэдэгдсэн юм. Харин Европын Холбоо Ираны Засгийн газар гэрээг хангалттай хэрэгжүүлж байгаа гэж үзээд АНУ-ын хоригийн эсрэг байр суурьтай байна.

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майкл Помпео “Энэхүү хориг Вашингтоны зүгээс Иранд авч хэрэгжүүлсэн хамгийн хатуу хориг арга хэмжээ байх болно. Терроризмыг санхүүжүүлэгч хамгийн том улсыг зогсоох зорилготой. Бидний авч хэрэгжүүлж байгаа хориг арга хэмжээнүүд хэдийн үр нөлөөгөө өгөөд эхэлсэн. Ираны газрын тосны экспорт сая гаруй баррелиар буураад байна. Энэ тоо цаашид ч нэмэгдэх болно” гэж мэдэгдлээ.

Харин Ираны Парламентын үндэсний аюулгүй байдал гадаад бодлогын хорооны дарга Хешматоллах Фалахатпишех “Вашингтоны энэ арга хэмжээ бол зүгээр л сэтгэл зүйн дайралт. Бид хориг арга хэмжээ ямар байдгийг мэддэг улс. Байдал тэгтлээ муудна гэж бодохгүй байна. Иран улс газрын тосыг шаардлагатай хэмжээнд экспортолж чадна” гэсэн байна.

Ираны эсрэг хориг сэргэсний дараа зах зээлд нийлүүлэлтийн хомсдол үүсэж болзошгүй гэсэн шалтгаанаар ханш өсөж байсан бол даваа гарагт нийлүүлэлт нэмэгдэж магадгүй нөхцөл байдал үүсээд байна. Үүнээс шалтгаалаад зах зээлд газрын тосны ханш унаж байна. Өнгөрсөн сард ОПЕС гарцаа өдрийн 430 мянган баррелиар нэмж 33.3 сая баррель болгосон юм. Үүний зэрэгцээ Вашингтоны эрх баригчид өөрийн улсын үйлдвэрлэгчдэд гарцаа нэмэх чиглэл өгөхөөс гадна Саудын Арабын гарцыг мөн өсгөх лобби явуулах төлөвлөгөөтэй байгаа нь мөн ханш унах хүчин зүйл болж байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### ОПЕС-ийн гишүүд газрын тосны гарцаа бууруулах талаар хэлэлцэж эхэллээ

Ням гарагт Абу Дабид болсон уулзалтаар ОПЕС-ийн гишүүн орнууд газрын тосны гарцыг бууруулах асуудлыг хэлэлцлээ. Оман улсын Газрын тосны сайдын мэдээлснээр гишүүн орнууд гарцыг бууруулах талаар бодолцож эхэлсэн, 2019 онд гарцыг өдөрт нэг сая баррелиар танах боломжийг ярилцаж эхэлсэн байна. “Хэрэв ирэх онд гарц өнөөдрийн түвшинд байвал дэлхийн зах зээлд нийлүүлэлтийн илүүдэл үүсэж, улмаар 2014 оныхтой адил үнийн уналт бий болох магадлалтай” гэж ОПЕС-оос томилсон Техникийн хороо тооцоолсон байна. 10-р сард Саудын Араб өдрийн гарцаа 2016 оноос хойших хамгийн дээд цэгт хүргэсэн бол өнгөрсөн долоо хоногт АНУ-ын шатдаг занарын олборлолт өдрийн 11.6 сая баррель болж дээд түвшинд хүрсэн, мөн ОХУ 10-р сард өдрийн 11.4 сая баррелийг олборлосон нь Зөвлөлтийн дараах үеийн дээд хэмжээ болжээ.

Гол үйлдвэрлэгчид гарцаа өсгөсөн, АНУ-д нөөц нэмэгдсэн, хоригийн нөлөөгөөр Ираны экспорт төдий л буурах төлөвгүй байгаа зэрэг шалтгааны улмаас зах зээлд газрын тосны үнэ буурч, Brent төрлийн тосны үнэ сүүлийн зургаан сарын хугацаанд анх удаа 70 ам.доллараас доош ороод байгаа юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## БУСАД МЭДЭЭ

### Монголбанк: ОУВС-ийн 36.33 сая ам.долларын санхүүжилт дансанд орж ирсэн

Олон Улсын Валютын Сангийн тав дахь шатны үнэлгээний санхүүжилт болох 36.22 сая ам.доллар дансанд орж ирсэн гэж Монголбанк мэдээллээ.

Ингэснээр Монгол Улсын гадаад валютын албан нөөцийн хэмжээг нэмэгдүүлжээ. "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Олон Улсын Валютын Сан Монгол Улсад шууд 217.33 сая ам.долларын санхүүжилт олгосон юм. Харин олон улсын банк санхүүгийн байгууллага болон донор орнуудаас 2017 онд нийт 728 сая ам.долларын санхүүжилт хийгдсэн бол 2018 онд нийт 836 сая ам.долларын санхүүжилт хүлээгдэж байна гэж Монголбанк мэдээллээ.

Олон Улсын Валютын Сангийн Захирлуудын зөвлөл 10-р сарын 31-ний өдөр хуралдаж, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн тав дахь шатны үнэлгээний тайланг хэлэлцэж баталсан юм. Тус үнэлгээгээр төсвийн тоон үзүүлэлтүүд зорилтоос даван биелж, гадаад валютын нөөц зэрэг хөтөлбөр хэрэгжүүлэх гүйцэтгэлүүд зорилтыг хангахын хамт Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг байна гэж дүгнэжээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### 2019 оны эдийн засгийн гол эрсдэлүүд эрдсийн үнийн хэлбэлзэл гэж бодлого боловсруулагчид үзэж байна

Экспортын голлох бүтээгдэхүүн болох зэс, алт, төмрийн хүдэр, нүүрсний үнэ 2019 онд буурах, газрын тосны үнэ нэмэгдэхээр байгаагаас шалтгаалан худалдааны нөхцөл муудах эрсдэлтэй гэж Төв банк мэдээллээ.

Харин төсөв талаас төсвийн орлого бүрдэхгүй байх нь эдийн засагт тулгарах гол эрсдэл гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөл онцолж байсан юм.

Сангийн яам төсвийн орлогын гүйцэтгэлд учирч болзошгүй эрсдэлийг үнийн хэлбэлзэл гэж мөн тодорхойлсон байна. Тухайлбал АНУ, БНХАУ-ын "Худалдааны дайн", АНУ-ын Засгийн газраас Ираны цөмийн хөтөлбөрийн эсрэг авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээ, Турк улсын эдийн засгийн хямрал, Бээжин хотын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд гангийн үйлдвэрлэлийг багасгах бодлого зэрэг нь энэ оны долоодугаар сараас эхлэн эрдэс бүтээгдэхүүний үнэ тогтворгүй байхад нөлөөлсөн байна. 2019 оны Төсвийн тухай хуулиар нийт орлогын гуравны нэгийг уул уурхайн салбараас бүрдүүлэхээр төлөвлөсөн юм.

Харин уул уурхайн салбарын орлогын 86 хувийг зөвхөн зэс, нүүрсний экспортоос бүрдүүлэхээр төлөвлөж байна. Ирэх оны төсөвт нэг тонн нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 75.9 ам.доллараар тооцжээ. Харин зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 6222 ам.доллар байхаар тооцоод байна. Харин Олон Улсын Валютын Сан, Дэлхийн банк, Австралийн нөөц, эрчим хүчний байгууллага болон "Bloomberg"-ийн шинжээчид цаашид нүүрсний үнэ төдийлөн хэлбэлзэхгүй гэж үзээд 2018 оны дундаж үнийн төсөөллийг өөрчлөлгүй тонн нь 202 ам.долларт хэвээр үлдээжээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



### S&P: Монгол улсын зээлжих зэрэглэлийг дээшлүүлэхэд төсвийн үзүүлэлтүүд голлон нөлөөлөв

"S&P" агентлаг Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийг "B"-аас "B" болгон дээшлүүлж, төлвийг тогтвортой хэвээр хадгалсан байна. Түүхий эдийн үнийн өсөлт, төсвийн сахилга бат, эдийн засгийн өсөлт зэргээс үүдэж төсвийн үзүүлэлтүүд сайн байгаа нь зээлжих зэрэглэлийг дээшлүүлэх шалтгаан болсон байна.

Мөн Монгол Улсын эдийн засаг 2021 он хүртэл дунджаар 5.6 хувиар өснө гэсэн хүлээлттэй байгаа гэж "S&P" агентлаг мэдээллээ. Уул уурхайн томоохон мега төслүүдэд ахиц гарсныг дурдсан байна. Тухайлбал, "Тавантолгой" төсөлд дөрвөн тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татахаар ажиллаж байгаа, "Оюу Толгой" төслийн хоёр дахь шатны бүтээн байгуулалтын ажил явагдаж байгаа нь зээлжих зэрэглэлийг дээшлүүлэхэд эергээр нөлөөлсөн байна. Мөн Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөрийн хүрээнд орж ирж буй донор орнуудын санхүүжилт Монгол Улсад санхүүгийн том дэмжлэг болж байгаа гэж үзжээ.

2015-2016 онд Монгол Улсын эдийн засагт үүссэн хүндрэлийн дараа эдгээр ахиц гарсан нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж байгааг шинжээчид онцолж байна. Хэдий тийм боловч Монгол Улсын эдийн засаг түүхий эдийн үнээс хамааралтай эмзэг хэвээр байгаа юм. Энэ нь эдийн засгийг тогтворгүй байхад нөлөөлж байгаа гэж "S&P" агентлаг дүгнэжээ.

Зээлжих зэрэглэлийг дээшлүүлэхээс өмнө Хөгжлийн банк олон улсын зах зээлээс 500 сая ам.долларын бонд 7.25 хувийн хүүтэй босгосон юм. Засгийн газар 2021 онд "Мазаалай", 2022 онд "Чингис", 2023-2024 онд "Гэрэгэ", "Хуралдай" бондуудын өрийг төлөх хуваарьтай байна. Засгийн газар олон улсын зах зээлд бонд гаргана гэж албан ёсоор мэдээлээгүй ч өрийн менежмент хийх талаар судалж, ажиллаж байгаа гэж Сангийн яам мэдээллээ. Одоогоор хоёрдогч зах зээлд "Гэрэгэ" бондын үнийн түвшин 11 дүгээр сар гарснаас хойш нэг хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Харин хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн түвшин 6.591 байгаа юм. Хамгийн ойр төлөх "Мазаалай" бондын хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн түвшин 5.612 байна. Энэ нь 11 дүгээр сар гарснаас хойш 3.88 хувиар буурсан үзүүлэлт болж байгаа ажээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.